

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас 2019 оны 4-р сарын дугаар

Тэргүүн мэдээ

Япон-Монголын сургалтын эмнэлгийн барилгыг хүлээлгэн өгөх ёслолын арга хэмжээ зохион байгуулагдлаа.



4 сарын 1-ний өдөр Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Япон-Монголын сургалтын эмнэлэг барьж байгуулах төсөл”-ийн хүрээнд Япон-Монголын сургалтын эмнэлгийг хүлээлгэн өгөх ёслол зохион байгуулагдлаа. Ёслолын үйл ажиллагаанд Япон улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Такаока Масато, Ерөнхийлөгчийн зөвлөх Амарсайхан нарын олон төлөөлөл оролцсон ба Монгол улсад анхны сургалтын эмнэлгийн хувьд өндөр чанартай эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ улсын хэмжээнд эмнэлгийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх төв болно гэдэгт итгэл дүүрэн байгаа тухай дурьдлаа. Мөн Техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд эмнэлгийн зөв зүйтэй менежмент удирдлагад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид байгууламжийн дотоод бэлтгэлийг хангаж 2019 оны 6-р сард эмнэлгийн үйл ажиллагааг хэсэгчлэн нээхийг зорьж байна.

Төслийн хэрэгжилт

“Байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх” тухай санамж бичигт гарын үсэг зурав.



4-р сарын 18-ны өдөр Японы ЖДҮ эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Рассети идээлэх технологи ашигласан арьс ширэн бренд хөгжүүлэх суурь судалгаа”-ны Япон талын гүйцэтгэгч болох Ямагүчи Сангё ХК нь Монгол Шевро ХК, Мон Ирээдүй ХХК-тай хром ашиглаагүй байгальд ээлтэй Рассети идээлэх технологийг нэвтрүүлэх санамж бичигт гарын үсэг зурлаа. Дээрх хоёр аж ахуйн нэгж цаашид дээрх технологийг ашигласан арьс ширэн брендийг бий болгохоор ажиллах бөгөөд 2019 оны намар Японд туршилтын бүтээгдэхүүнээ танилцуулах юм.

Газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт, ойн салбарын ажлын хэсэг (LULUCF) хуралдав.



4-р сарын 19-ний өдөр ТХА “Хүлэмжийн хийн тооллого хийх чадавхийг бэхжүүлэх замаар үндэсний хүлэмжийн хийн тооллого хийх мөчлөгийг тасралтгүй сайжруулах төсөл”-ийн Газар ашиглалт/газар ашиглалтын өөрчлөлт, ойн салбарын ажлын хэсэг (LULUCF) хуралдав.

Монгол дахь хүлэмжийн хийн тооллогын судалгааны хүрээнд тал нутаг дахь хүлэмжийн хийн ялгаралт ба шингээлтийн хэмжээг хэмжин тогтоох нь нэн тэргүүний зорилт юм. Ажлын хэсгийн хуралд уг төслийн монгол талын хэрэгжүүлэгч байгууллага болох Байгаль орчин уур амьсгалын сан болон МУИС-ийн судлаачид оролцож 2019 оны зун хэрэгжүүлэх хөрс, биомассын мэдээлэл цуглуулах судалгааны чиглэл ба тооцооны аргачлалыг бататгав.

Японы Коосэний анхны төгсөгчдийг хүлээн авах ёслол, ажлын байр танилцуулах өдөрлөг болов.



ИХЗ-ийн “Инженер технологийн дээд боловсрол төсөл”-ийн (M-JEED) шугамаар Японы Коосэнд элсэн 3 жилийн хугацаанд мэдээллийн технологи, цахилгааны инженер, механик инженер зэрэг чиглэлээр суралцан төгссөн анхны 21 оюутан 2019 оны 3 сарын сүүлээр эх орондоо буцаж ирсэн юм. 4 сарын 9-ний өдөр эдгээр оюутнуудыг хүлээн авах ёслол болон шилдэг аж ахуйн нэгжүүд ба оюутнуудыг холбож өгөх зорилготой ажлын байрны өдөрлөг болов. Өдөрлөгт уг төслөөр Япон суралцах гэж буй оюутнууд бас оролцож, төгсөж ирсэнийхээ дараа хэрхэн ажлын байртай болох талаар ойлголт авав. Инженер технологийн дээд боловсрол төслийн хүрээнд цаашид эдийн засгийг төрөлжүүлэх ажлын голыг үүрэх инженерийн чиглэлийн боловсон хүчний бэлтгэх үүднээс Японы Коосэн болон их, дээд сургуульд оюутан явуулах хөтөлбөр үргэлжлэх юм.

Аймгуудад хөгжлийн асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж байна.



Хөгжлийн төлөвлөлтийн судалгааны хэлбэрийн ТХА-ны “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийн үйл ажиллагааны хүрээнд ЖАЙКА-ийн мэргэжилтнүүд Монгол Улсын бүх аймгуудаар явж хөгжлийн тулгамдсан асуудлууд болон хөгжлийн боломжийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулж байна. 4-р сарын 8-ны өдөр Орхон аймгийн Эрдэнэт хотод болсон хэлэлцүүлэгт төр захиргааны ажилтнууд болон иргэдийн төлөөлөл болох гучаад хүн оролцож, 2 цаг гаруй идэвхтэй санал солилцов. Энэхүү төслийн хүрээнд аймгуудын саналыг нэгтгэн улс ба орон нутгийн түвшний хөгжлийн чиг хандлагыг тодорхойлон гаргах юм.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавхи бэхжүүлэх төслийн Хамтарсан Зохицуулах Хорооны анхдугаар хуралдаан болов.



4-р сарын 16-ны өдөр ТХА-ны “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавхи бэхжүүлэх төсөл”-ийн Хамтарсан Зохицуулах Хорооны (JCC) анхдугаар хуралдаан болов. Энэхүү төслийн хүрээнд хөгжлийн бодлого ба санхүүжилтийн эх үүсвэртэй уялдсан Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) боловсруулах, хэрэгжүүлэх, удирдах тогтолцоог бий болгох, боловсон хүчин сургаж бэлтгэх зорилго тавьж байгаа бөгөөд 2019 оны 2 сараас эхлэн 4 жилийн хугацаанд хэрэгжих юм. Хамтарсан Зохицуулах Хорооны (JCC) хуралдаанд ҮХГ ба Сангийн яамны зүгээс Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулахад тулгарч буй асуудал болон хөтөлбөр боловсруулахдаа санхүүжилтийн бодлоготой хэрхэн уялдуулж буй талаар танилцуулга хийж, цаашдын үйл ажиллагааны төлөвлөөг тохиролцов.

Бусад төслийн үйл ажиллагаа.

- 4 сарын 17: Урт хугацааны мэргэжилтэн Тада Акира (“Мал эмнэлэг, МAA-н салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх төсөл”) ирэв.
- 4 сарын 29: Урт хугацааны мэргэжилтэн Умэмура Кожи (“Мал эмнэлэг, МAA-н салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх төсөл”) буцав.

ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагааны танилцуулга

Байгалийн ухааны хичээлийн туршилтыг дэлгэрүүлэхийг зорьж байна.



Монголд туршилтад ашиглах материал хомс, багш нар туршилт хийх арга сайн мэддэггүй зэрэг шалтгаанаар байгалийн ухааны хичээл дээр бараг туршилт явуулдаггүй. Сайн дурын гишүүн Фүкүшима Мики (2017 оны 2-р ээлж/ Байгалийн ухааны багш/ Дундговь аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар) байгалийн ухааны хичээлийн туршилтыг дэлгэрүүлэхээр шамдан ажиллаж байгаа бөгөөд 4 сарын 8-ны өдөр хамт ажилладаг багш нартайгаа орон нутгийн 15 багшийг хамруулан “Гарын доорх материал ашиглан туршилт хийх нь” сэдэвт семинар зохион байгуулав. Орон нутагт олдох боломжтой цаасан аяга, нийлэг уут, гар чийдэн зэргийг ашиглан сарны хөдөлгөөн, соронзон хүч, дуу чимээний туршилтыг зааж өгөхийн зэрэгцээ туршилтын бусад аргыг нийтэлсэн боловсролын салбар зөвлөлийн [цахим хуудсыг](#) мөн танилцуулан байгалийн шинжлэх ухааны практик туршилтын нөү-хауг дамжуулсан байна.

Сайн дурын бусад үйл ажиллагаа.

- Дэлхий даяарх ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагааны тэмдэглэл: Сайн дурын гишүүн Абэ Юми (2018 оны 1-р ээлж/ Дуу хөгжим/ Сэлэнгэ аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар) [Нийтлэлийн эх](#)



ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбоо

2018 оны Шилдэг туршлага нэвтрүүлэгч (1)



Шинэ Анагаах Ухаан Их Сургуулийн багш С.Чулуунцэцэг Япон улсад болсон “Улаанбаатар хотын гэр хороололд оршин суугч иргэдийн эрүүл мэндийг сайжруулах үйл ажиллагаанд оролцон ажиллах сувилахуйн мэргэжилтэн бэлтгэх сургалт (2014 он)”-нд оролцсоноосоо хойш Японд олж авсан мэдлэгтээ тулгуурлан Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв, харъяа өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сувилагч зэрэг нийт 845 хүнд, мөн хэвтэн эмчлүүлэх тасгаар үйлчлүүлсэн 2800 орчим үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн сургалт зохион байгуулсан. Мөн түүнчлэн, Сургалт Төгсөгчдийн Холбооны дэмжлэгээр “Өндөр настны эрүүл мэндийг сайжруулахад өрхийн сувилагчийн оролцоо” сэдэвт семинар зохион байгуулж байсан. Түүний энэхүү хүчин чармайлтыг үнэлэн ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбооны 2018 оны “Шилдэг туршлага нэвтрүүлэгч”-ээр шалгарууллаа.

[Сургалт төгсөгчдийн холбооны цахим хуудас](#)

Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага.(ЖАЙКА)

Монгол дахь төлөөлөгчийн газар.

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс

(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 /E-mail: mg_oso_rep@jica.go.jp

Web: www.jica.go.jp/mongolia/index.html /FB: [JICA Mongolia](#)